

МЭДЭЭЛЭЛЖСЭН НИЙГЭМ ДЭХЬ БАГШ НАРЫН МХТ-ИЙН ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АСУУДАЛД

Л.Мөнхтуяа

МУБИС -ийн Компьютер Мэдээллийн Технологийн Сургууль

Хураангуй:

Зуун бүхэн өөрийн онцлогтой байдаг бөгөөд ХХI зууныг бид бүхэн мэдээллийн зуун гэж нэрлэдэг. Үнэхээр ч мэдээллийг хэн хамгийн түрүүнд хүлээж авч чадаж байна, тэр хүн илүү ихийг бүтээж чадаж байна. Багш бидний хувьд зөвхөн мэдлэгийг дамжуулах бус, мэдээлэлийг олж авах, түүнийгээ боловсруулах арга замд суралцагчдаа сургах нь нэн тэргүүний зорилт билээ. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд багшийн МХТ-ийн чадварын асуудал хөндөгдөж байгаа юм.

Түлхүүр үг:

Мэдээлэл Харилцааны Технологи, багш, суралцагчид, компьютер,

1. Багшийн хөгжлийн тухай

Дэлхийн аль ч улс орны хувьд үеийн үед нийгмийн ХӨГЖЛИЙН ХӨШҮҮРЭГ нь боловсролын салбар байсан бөгөөд боловсролын салбарт хөгжлийн хүчин зүйл нь багшийн хөгжил юм. Багшийн хөгжил гэдэг нь цаг үеийн өөрчлөлтийг соргог мэдрэх сэтгэлгээ, арга барил, хайрлцаа, лага, зан байдлаа өөрчлөн өөрийгөө тасралтгүй хөгжүүлж байхыг хэлнэ.

Манай оронд 1990-ээд оноос өмнө багшийг хөгжүүлэх талаар төрөөс нэгдсэн арга хэмжээ авдаг байлаа. Багш нарын мэргэжил дээшлүүлэх институт 5 жил тутамд багш нарын мэргэжлийг дээшлүүлэх ажлыг системтэй хийж байсан. Зах зээлд шилжсэн 1990-ээд оны үеэс энэ ажил зогссон ч нийгмийн шинэчлэл, өөрчлөлтийн явцад багш бэлтгэх болон давтан бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх салбарт ахиц гарч, олон төсөл, хөтөлбөр хэрэгжиж, багш нар сургалт семинарт хамрагдах, сургуулийн материаллаг бааз бэхжүүлэх зэрэгт тодорхой ажлууд хийгдсээр ирлээ. Багш хөгжиж төлөвших 3 үе шаттай. Үүнд:

1. Багшийн мэргэжил эзэмшихийн өмнөх үе буюу мэргэжлийн чиг баримжаа өгөх үе
2. Багш мэргэжил эзэмших үе
3. Багшийн хөгжлийн үе

Багшийн тасралтгүй сурах хөгжих явцын үр дүнд боловсролын салбарт шинэ мэдлэг, шинэ хандлага шинэ итгэл, үнэмшил соёлын үнэт зүйлс бий болж, тоон болон чанарын өөрчлөлт, шинэчлэл гарч байдаг. Өөрөөр хэлбэл багшийн хөгжил нь боловсролын салбарт болон сургуулийн өөрчлөлт шинэчлэлтийг араасаа дагуулдаг жамтай. [1]

2004-2005 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД БЭЛТГЭГДСЭН БАГШИЙН ТОО (15)

Хүснэгт N:1

	Нийт	эм	диплом	бакалавр	магистар
Багш мэргэжилтэн	2779	2221	121	2356	285

2. Багшийн олон талт загвар

Өнөөдрийг хүртэл манай орны хувьд багшийн загвар нь харьцангуй тогтонги мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн, олон талт бус шинжтэй, хувь хүний хөгжлийн талыг орхигдуулсан зэрэг сул талтай байгааг эрдэмтэд авч үзсэн байдаг. Өөрөөр хэлбэл “мэдлэгтэй багш” бэлтгэхэд чиглэгдсэн байгаа юм. Нийгмийн, хүүхэд залуучуудын болон бусад сонирхлын бүлгийн хэрэгцээг бүрэн дүүрэн ханган үйлчлэх чадамж бүхий, бүтээлч, тасралтгүй хөгжигч тухайн бие хүнийг сайн багш гэж ойлгож болно. [4]

Багш бие хүний загварын үндсэн шалгуурын дараах 5 чадамж байдаг байна. Үүнд:

1. Судалгааны чадамж.

- Мэдээллийг цуглуулах, боловсруулаллах чадвар
- Өөрчлөлт шинэчлэлтийг мэдрэх, хүлээн авах, бүтээлчээр хэрэгжүүлэх чадвар ...

2. Харилцааны чадамж

Мэдээлэл харилцааны технологийг сурах-сургах үйл явцад хэрэглэх, түүнийг ашигла бусадтай харилцах чадвар ...

3. Сургах/сургах чадвар

-Тасралтгүй сурах, хөгжих, мэдээллийн эх үүсгүүрийг олж авах, хэрэглэх, бүтээлчээр ашиглах, шинийг санаачлах, шинийг бүтээх чадамж, чадвар ...

4.Хувь хүний чадамж

-Оюуны чадамж, чадвар...

5. Хэрэглээний талбар дахь боловсролжих зайлшгүй хэрэгцээнд тохирсон чанартай үйлчилгээ үзүүлэх чадамж

- ... Өөрийн орны болон дэлхий нийтийн боловсролын хөгжийн чиг хандлагыг ойлгон, цаг алдалгүй хүлээн авч бүтээлчээр хэрэгжүүлэн өөрийн гэсэн хувь нэмрээ оруулан, нөөц баялгийн эх үүсгүүр болох шинэ мэдлэг бүтээх замаар өнөөгийн нийгмийг хөгжүүлэх...


3. Багшийн МХТ-ийн хэрэглээ, чадварыг тодруулах судалгааны тайлан

ЕБС-ийн багш нар МХТ-ийг хэрхэн ашиглаж байгаа, тэдний чадварыг тодруулах зорилгоор дараах судалгааг хийсэн болно. Судалгаанд Архангай, Баян-Өлгий, Булган, Дархан-Уул Дорнод, Орхон, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хэнтий аймаг, Улаанбаатар хотын төрөл бүрийн мэргэжлийн 151 багш оролцсон болно.

Хүснэгт №2

Аймгууд	Багшийнтоо
Архангай	8
Баян-Өлгий	9
Булган	8
Дархан-Уул	10
Дорнод	10
Орхон	15
Сүхбаатар	7
Сэлэнгэ	9
Төв	12
Увс	13
Ховд	10
Хэнтий	15
Улаанбаатар	25

График №1



Багш нараас авсан судалгаанд дараах саналыг өгсөн байна. Үүнд:

1. МХТ-ийг сургалтад хэрэглэх сургалт, семинарт тэр бүр хамрагддаггүй.
2. МХТ-ийн талаарх ойлголт тааруу, мэдлэг чадвараа хэрхэн дээшлүүлэх арга замаа мэддэггүй.
3. МХТ-ИЙН хэрэглээг бий болгох тодорхой шалгуурыг мэдэхгүй.
4. МХТ-ийг сургалтад хэрэглэх орчин янз бүр.
5. Сургуулийн удирдлага дэмжих тал дээр хангалттай бус.

1. Мэргэжлийн мэдээлэл зүйн багшгүй учраас мэдлэгээ дээшлүүлэх боломж тааруу

Дээрх судалгаанд гарсан саналыг харгалзан орчин үеийн багшийн чадамжийг бүрдүүлэх голлох нөлөө үзүүлж байгаа МХТ-ийн чадварыг хэрхэн төлөвшүүлэх боломжийг авч үзье.

4. Мэдээлэлжсэн нийгэм дэх боловсролын зорилт

Өнөөдөр дэлхийн аль ч оронд нийгмийн хөгжлийг хурдасгах, нийгэмд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд МХТ-ийн хөгжил, түүнийг дагалдсан даяаршлын үйл явц үнэтэй хувь нэмэр оруулж чадах нь улам тодорхой болж байна. Эдийн засагт мэдээллийн үйлдвэрлэл, хадгалалт, шинэчлэн боловсруулалт, борлуулалтын салбар давамгайлсан харилцааг мэдлэгт суурилсан эдийн засгийн харилцаа гэнэ. Мэдлэгт суурилсан нийгэм эдийн засгийн харилцаанд мэдээлэл, мэдлэг нь шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ. Даяаршлын үеийн боловсролын салбарын зорилт нь шинжлэх ухаан, технологийн цогц мэдлэгтэй, түүнийг хэрэглэх чадвартай ажиллах хүч бэлтгэх явдал юм.

МХТ нь хүний заавал эзэмшвэл зохих дадал болсон байна. Даяаршлын үеийн суралцагч МХТ-ийн суурь боловсролтой байх зайлшгүй шаардлагатай. Сургалтад мэдээллийн хэрэгсэл Хэрхэн нэвтэрсэн байдлыг авч үзвэл[9]:

Хүснэгт № 3

Мэдээлэлийн хэрэгсэл	Хэвлэмэл ном	Шуудангийн үйлчилгээ	Радио	Кино	Телевиз	Компьютерийн сүлжээ	Интернет
Боловсролд нэвтэрсэн хугацаа	XV зуун	1924	1830	1930	1957	1980	1993

Компьютерийн хангалтыг сүүлийн 4 жилийн байдлаар үзүүлбэл[14]:

он	Тоо ширхэг	Олгосон сургуулийн тоо	Үнийн дүн/сая төгрөг/	Усын төсвийн хөрөнгөөр /сая/ төг/	Эзлэх хувь	Нэг компьютерийн үнэ /мян/төг/
2000	532	119	328.3	40.8	12,4	617.1
2002	552	137	292.6	0.8	0.3	530.1
2003	659	131	528.8	10.4	1.9	802.4
2004	1319	330	709.0	290.0	40.9	510.1
ДҮН	3062	717	1858.7	342.0	13.8	614.9

5. Багшид МХТ-ийг ашиглах чадвар төлөвшүүлэх асуудал


МХТ-ийг сурах үйл явцын үе шатууд

Хүснэгт № 4

Танин мэдэх	A	МХТ-ийн хэрэгслүүд
Сурах	B	МХТ-ийн хэрэгслийг ашиглах
Хэзээ, хаана гэдгийг ойлгох	C	Тодорхой зорилгод хүрэхийн тулд МХТ-ийг ашиглах
Мэргэшил	D	МХТ-ийн хэрэгслийг ашиглах

МХТ-ийг ашиглах чадвар эзэмшүүлэх үе шатууд

Схем 1



1.Багш нар МХТ-ийн хэрэгслийн талаар мэдлэгтэй болж МХТ-ийг хэрэглэх чадвар эзэмшинэ. Үүнд:
Баримт боловсруулах

- Тооцоолох
 - Мэдээллийн сан байгуулах
 - Программ хангамжуудтай танилцах
- Эдгээрийг технологийн хялбар аргаар эзэмших ёстой.

2.Багш нар МХТ-ийн талаархи үндсэн ойлголттой болсон гэж үзвэл МХТ-ийн хэрэгслүүдийг тодорхой хичээлүүдэд:

- Хэлний . Байгалийн шинжлэх ухаан болон эрүүл мэнд
- Математик
- Дуу хөгжим, дүрслэх урлаг зэрэгт хэрэглэх

3. Нэмэлт мэдээлэл оруулах үе шатад багш нар МХТ-ийг өөрсдийн мэргэжлийн хичээлээ заахдаа хэрэглэж эхэлнэ. Тэд өөрсдийн олж авсан мэдлэг болон чадвараа өөр бусад хичээлийн хөтөлбөртэй интеграцчлах хэрэгтэй болно.

4. Хувиргах үе шатад МХТ-ийг сургалтад нэвтрүүлснээр сургууль, хичээлийн менежмент, боловсролд өөрчлөлт гарна. Тухайлбал шавь төвтэй сургалт явагдах нэг үндэс бүрэлдэн Хичээлүүд хоорондоо уялдаа холбоотой, суралцагчид хамтран ажиллаж, интернэтээр бусадтай харилцахад гарч буй өөрчлөлтөд үнэлгээ өгөх.

Багш боловсролд МХТ-ийг үр дүнтэй ашиглахад чиглэсэн тулгуур зарчмууд

1. Технологийг багш бэлтгэх боловсролд оруулах
2. Технологийг контекст-д оруулах
3. Суралцагчид технологи ашиглалтад тулгуурласан сурах шинэлэг орчинд суралцах боломжыг олгох

Багш нарыг бэлтгэхдээ:

- Онолд биш хэрэглээний арга барилд анхаарах
- Хичээл заахад МХТ ашиглах
- Шат дараалалтай мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах, бие даан суралцах боломж бүрдүүлэх
- Багш нарын шинэчлэлийг хичээлийн эрхлэгч, захирал, орон нутгийн боловсролын байгууллагууд дэмждэг байх.

Багшийг хөгжүүлэх хөтөлбөрт байгаа МХТ-ийн бичиг үсгийн боловсрол [13]

Хүснэгт №5

Нэгж хэсгүүд	Тодорхойлолт	Тайлбар
A1.МХТ-ийн үндсэн ойлголт	-МХТ-ийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн үүрэг, тэдгээрийг танин мэдэх	Энэ нь зөвхөн МХТ-ийн үндсэн ойлголтыг мэдээд зогсохгүй өөрийгөө хөгжүүлэхэд МХТ-ийг ашиглах багш суралцагчдын үйл ажиллагааны цөм болно.
A2. Компьютерийн хэрэглээ ба файл зохион байгуулах	Программ хангамжийн системүүдийг өөрийн үйл ажиллагаанд ашиглах	Энэ нь бүх багш нар өөрийн зорилгодоо МХТ ашиглахад болон суралцагчдад МХТ ашиглахад туслах зайлшгүй хэрэгтэй.
A3. Баримт боловсруулах WORD	Төрөл бүрийн загвар бүхий баримт үүсгэж ашиглах	МХТ-ийн өргөн хэрэглээний программ. Багш нарын бүх хичээлд зайлшгүй хэрэглэгддэг.
A4. Хүснэгт зохион байгуулах	Хүснэгтэн мэдээллийг үүсгэх, ашиглах ойлголттой болох	ангийн үнэлгээний хүснэгт үүсгэх, байгуулах ашиглах ойлголттой болох
A5. Өгөгдлийн сантай ажиллах	Өгөгдлийн сан үүсгэж ашиглах өргөн ойлголттой болох	Өнөөдөр өгөгдлийн санд тулгуурласан мэдээллийн систем нь ашиглагдаж байна. Өгөгдлийн сангийн талаарх ойлголт нь багш нарт чухал юм.
A6. Илтгэл, танилцуулга бэлтгэх,	Илтгэл, танилцуулга бэлтгэх ашиглах	Багшлах үйл ажиллагаанд илтгэл, танилцуулгыг чадварлагаар бэлтгэх нь ихээхэн тустай.
A7. Мэдээлэл ба харилцаа	Компьютер, мэдээллийн эх үүсвэрийн тусламжтайгаар бусад хүмүүстэй харилцах	Багшид х эрэгцээт мэдээлэлүүдийг интернэтээс хайх, электрон шуудангаар харилцах нь чухал
A8. Нийгэм ба ёс зүйн асуудал	Нийгэм, эдийн засаг ёс зүйн асуудлуудыг МХТ-ийн тусламжтайгаар мэдэх	МХТ-ийг ашиглахдаа зохиогчийн эрх хүндэтгэх, мэдээллийг нөөцлөх, вируснээс хамгаалах ойлголтын талаар багш сурагчдад таниулах
A9. Мэргэжил ба МХТ	өөрийн ажил мэргэжилд нь чухал үүрэгтэй гэдгийг ухамсарлах	Энэ нь багшийн хөгжлийн нэг бөгөөд багшлах үйл ажиллагаандаа хэсэг МХТ-ийг хэрэглэнээр сургалтыг улам МХТ чанаржуулах ойлголт.

МХТ-ийг дэмжих сүлжээнүүд:

- МХТ-ийн хөрөнгө оруулалт ашиглагдсан эсэхийг баталгаажуулах
- Сургуулиудын ижил мэргэжлийн багш нарыг холбох
- Бусад оронд хэрэглэж байгаа туршлагыг судлах

МХТ-ийг сургуулиудад хэрхэн ашиглаж байгааг үнэлэхдээ:

- Хэрхэн хэрэглэгдэж байгаа?
- Хэн хэрэглэж байгаа? (багш, сурагч, хичээлийн эрхлэгч)
- Ямар хичээлд ? (Зөвхөн мэдээлэл зүйд)
- Сургалтын төлөвлөгөө ба сургуулийн удирдлагатай холбоотой эсэх
- Шийдвэрлэх шаардлагатай гол гол хүндрэлүүд
- Боловсролын салбарт ерөнхийдөө нийцэж байгаа эсэх

5. Гадаад орнуудын туршлага

МХТ-ийн хөтөлбөрийн агуулга /Хятад/

Модуль 1: хичээлээ төлөвлөж эхлэх

Модуль 2: хичээлтэй холбоотой материал цуглуулах

Модуль 3: Суралцагчид мультимедиа ашиглаж илтгэл тавих сэдвүүд боловсруулах

Модуль 4: Суралцагчдын хийх бүтээлийн жагсаалт гарал

Модуль 5: Хичээлд ашиглах Нэмэлт материалын жагсаалт гаргах

Модуль 6: Суралцагчдад зориулсан Вэб сайт бий болгох

Модуль 7: Багшид хэрэгцээтэй материалын жагсаалт

Модуль 8: Ажлын төлөвлөгөө боловсруулах

Модуль 9: Хичээлийн төлөвлөгөө хамтран хийх

Модуль 10: Өөрийн боловсруулсан хичээлийн төлөвлөгөө бусдад таниулах

Б. Багш МХТ-ийг сургалтанд хэрэглэж буй хэлбэр /Солонгос/

1. Мэдээ мэдээллийг олж авах, хайх

2. Олсон МЭДЭЭЛЭЛД анализ хийх

3. Мэдээ, мэдээллийг санал болгох.

4. Маргаан мэтгэлцээн явуулах

5. Хамтарсан судалгаа шинжилгээ хийх

6. Мэргэжлийн хүмүүстэй санал солилцох

7. Интернэтээр дамжуулан найз нөхөдтэй болох

8. Мэдээ, мэдээллийг боловсруулах, гарын авлага бэлтгэх

Бие дааж хийх
боломжтой

Хамтарч үйл
ажиллагаа явуулах

6. Дүгнэлт, санал

Энэхүү өгүүлэлд багшийн хөгжлийн тухай, орчин үеийн багшийн чадамжийг төлөвшүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэх МХТ-ийн чадварыг хэрхэн төлөвшүүлэх тухай авч үзлээ. Багшийн МХТ-ийн чадварыг хөгжүүлэхэд:

1. Нэн тэргүүнд сургуулиудын компьютерийг интернэтийн сүлжээнд холбох. Ингэснээр компьютерийг зөвхөн бичгийн машины хүрээнд ашиглах бус МХТ-ийн харагддаг бол болгох нөхцөл бүрэлдэнэ.
2. Сургуулийн удирдлага, мэдээлэл зүйн багш нар хамтран ажиллах,
3. Багш нарын МХТ-ийн талаархи ойлголт, мэдлэг, чадвараас хамааруулан үе шаттай сургалтыг зохион байгуулах. (Аймгуудын боловсрол соёлын газар)
4. МХТ-ийг сургалтандаа хэрэглэж байгаа багш нарыг урамшуулах, ДЭМЖЛЭГ урууну
5. Бүсчилсэн сургалтыг зохион байгуулах.
6. Төр засгийн байгууллагаас сургуулиудын материаллаг баазыг бэхжүүлэх (LCD, бусад тоног төхөөрөмж...) тал дээр анхаарах хэрэгтэй байна.

Эх сурвалж

1. С.Батхуяг, Ш.Ичинхорлоо нар “Сурган хүмүүжүүлэх зүйн үндэс” УБ., 2006 он.
2. БХХ-2 “МХТ-ийн хэрэглээ” УБ., 2005 он.
3. Б.Бор, Нямаа “Сурган хүмүүжүүлэх зүйн зарим асуудал” УБ 1996 он.
4. Б.Жадамба, Ц.Батсуурь, Б.Пүрэв-Очир, Д.Пүрэвдорж “Багш боловсролын ирээдүй” УБ 2005 он.
5. Ш.Ичинхорлоо “Сургалт” УБ., 2004 он.
6. Ш.Ичинхорлоо “Багшийн ном” УБ., 2004 он.
7. Лавай “Боловсролын онол, арга зүйн сэтгүүл” No1, 2 УБ., 2004 он.
8. Ц.Оюун, Д.Түмэндэмбэрэл “Багшийн хөгжил” УБ., 2005 он.
9. Т.Сувдмаа “Цахим сургалт” УБ., 2005 он.
- 10 Ц.Чимэдлхам “Боловсролын салбарт МХТ-ийг нэвтрүүлэх онол, арга зүйн асуудал” УБ 2005 он.
11. Adapting education to the information age Seoul., 2003 он.
12. Educational system & practice in Japan February 2006 он.
13. Information and communication technology in education UNESCO 2002 он.
14. <http://mecs.pmis.gov.mn>
15. www.nso.mn
16. www.mongoleducation.mn
17. <http://www.ecdl-ru.com>
18. <http://www.infojournal.ru>